



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 26 өдөр

Дугаар А/312

Хэрлэн сум

Түүх, соёлын дурсгалуудыг зөөж,
тээвэрлэх зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.3, Засгийн газрын 2016 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Соёлын биет өвийг зөөж тээвэрлэх журам”-ын 1.4, 4.1, 5.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Соёлын өвийн хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг сайжруулах зорилгоор Баян-Овоо сумын Наран багийн нутагт орших Суварган дэгтийн тахилын хавтан чулуу, Хэрлэн сумын Тахилгат тосгоны нутагт орших Сүүл ухаагийн хүн чулуун хөшөөнүүдийг зөөж тээвэрлэн, Хэнтий аймгийн музейд байрлуулах зөвшөөрөл олгосугай.

2.Түүх, соёлын дурсгалуудыг зөөж тээвэрлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:	Д.Өнөрцэцэг	Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга:	Э.Сайнзаяа	Хэнтий аймгийн Музейн Эрдэм шинжилгээ, сан хөмрөг, олон нийтийн албаны дарга
Гишүүд:	Б.Өнөрбаяр	Хэнтий аймгийн Музейн Арга-зүйч, Бүртгэл мэдээллийн санч
	Б.Төгсжаргал	Хэнтий аймгийн Музейн Эрдэм шинжилгээний ажилтан
	Э.Буянбат	Хэнтий аймгийн Музейн Тайлбарлагч
	С.Өнөрбат	Хэнтий аймгийн Музейн зохион байгуулагч, харуулын ахлах
	Б.Гансүх	Хэнтий аймгийн Музейн жолооч
	С.Мөнхбаатар	Хэнтий аймгийн Музейн харуул

2.

3.Соёлын биет өвийг зөөж тээвэрлэх журмын 5.2 дугаар заалт харгалзан хамгаалагчаар Музейн захирал (Н.Нямсүрэн(-ыг томилсугай.

4.Дээрх түүх, соёлын дурсгалууд байршиж байсан газарт тэмдэг, тэмдэглэгээ хийж байршуулахыг Баян-Овоо сумын Засаг дарга (Д.Баянмөнх), Хэрлэн сумын Засаг дарга (М.Шүрэнцэцэг) нарт тус тус даалгасугай.

5.Түүх, соёлын дурсгалуудыг зөөж тээвэрлэх ажлыг холбогдох журмын дагуу зохион байгуулахыг Музейн захирал (Н.Нямсүрэн)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Д.Өнөрцэцэг)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ